



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн “Баруун бүсийн тамирчдыг олимпд бэлтгэх төв” ОНӨТҮГ-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан.

Аудитын код: ЗАА-2024/003/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай сум
2025 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506


Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Аудитор: Б.Мөнхнасан

Утас: 90066888

Цахим хаяг: munkhnasanb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

**БАРУУН БҮСИЙН ТАМИРЧДЫГ
ОЛИМПОД БЭЛТГЭХ ТӨВ
ОНӨТҮГ-ЫН ДАРГА
Г.ТҮВШИНБАТ-Д**

2025.03.15 № 343

танай

-ны №

-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв" орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

"Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв" орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

"Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв" орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь татаас санхүүжилтийн орлогоор 894,651,9 мянган төгрөгийн, бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлогоос 136,962,8 мянган төгрөгийн, бусад мөнгөн орлогоор 12,693,3 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна.

Аудитын гол асуудал


"Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв" орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар Цогт фитнесээс 3,496,1 мянган төгрөгийн түрээсийн орлого, "Ватт мах" компанийн ажиллуулж байсан рестораны түрээсийн 16,000,0 мянган төгрөг төлөгдөөгүй зэрэг зөрчил байна.

Бусад асуудлын хэсэг

"Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв" орон нутгийн өмчит

D:/disk/Албан бичиг/Дүгнэлт-2025

812502509



үйлдвэрийн газар нь үйл ажиллагааны мөнгөн орлогыг төлөвлөгөөний дагуу бүрэн зарцуулсан, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/


Мөрийн дугаар	Үзүүлэлт	оны 12-р сарын 31		оны 12-р сарын 31	
		2023		2024	
1	ХӨРӨНГӨ				
1.1	Эргэлтийн хөрөнгө				
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		8,606,135.26		9,063,477.51
1.1.2	Дансны авлага		5,287,499.99		5,846,070.95
1.1.3	Бусад авлага		41,608.55		
1.1.6	Бараа материал		33,822,694.00		38,554,774.01
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн		47,757,937.80		53,464,322.47
1.2.1	Үндсэн хөрөнгө		132,813,784.35		107,350,218.20
1.2.2	Биет бус хөрөнгө				
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн		132,813,784.35		107,350,218.20
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		180,571,722.15		160,814,540.66
2.1.1.1	Дансны өглөг				
2.1.1.2	Цалингийн өглөг				
2.1.1.3	Татварын өр		6,070,037.72		7,165,108.00
2.1.1.4	НДШ - ийн өглөг				
2.1.1.11	Бусад богино хугацаат өр төлбөр		20,643,001.89		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн		26,713,039.61		7,112,308.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн		26,713,039.61		7,112,308.00
2.3.2	- төрийн		22,874,000.00		22,874,000.00
2.3.6	Эзэмшигдийн өмчийн бусад хэсэг		150,000,000.00		150,000,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг		(19,015,317.46)		(19,015,317.46)
2.3.10	Тайлант үеийн үр дүн				(156,449.88)
2.3.11	Эздийн өмчийн дүн		153,858,682.54		153,702,232.66
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		180,571,722.15		160,814,540.66

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	оны 12-р сарын 31	
		2023	2024
1	Борлуулалтын орлого (цэвэр)	828,806,350.00	1,044,866,672.00
3	Нийт ашиг (алдагдал)		
4	Түрээсийн орлого	21,718,400.00	19,440,000.00



9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	861,294,965.68	1,043,923,121.88
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		1,100,000.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-32,488,615.68	-156,449.88
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-32,488,615.68	-156,449.88
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-32,488,615.68	-156,449.88
24	Орлогын нийт дүн	-32,488,615.68	-156,449.88
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	оны 12-р сарын 31	
		2023	2024
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1	Мөнгөн орлогын дүн (+)	829,046,670.00	1,044,308,101.04
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	110,722,050.00	136,962,817.04
	Татаас, санхүүжилтын орлого	717,984,300.00	894,651,900.00
	Бусад мөнгөн орлого	340,320.00	12,693,384.00
1	Мөнгөн зарлагын дүн (-)	816,474,535.20	1,038,609,858.79
	Ажиллагчдад төлсөн	238,002,303.60	306,281,767.80
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	70,395,341.25	91,774,245.18
	Бараа материал худалдан авахад төлсөн	43,558,359.75	48,187,292.73
	Ашиглалтын зардалд төлсөн	428,394,450.21	547,452,590.55
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	14,313,630.39	26,340,750.08
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	21,810,450.00	18,573,212.45
1	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	12,572,134.80	5,698,242.25
2	Мөнгөн орлогын дүн (+)		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,160,250.00	629,900.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,160,250.00	629,900.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		

2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-1,160,250.00	-629,900.00
3	Мөнгөн зарлагын дүн (-)	6,719,795.00	4,611,000.00
	Түрээсийн оглолт төлсөн мөнгө (ОНО- 30%)	6,719,795.00	4,611,000.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-6,719,795.00	-4,611,000.00
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	4,692,089.80	457,342.25
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,914,45.46	8,606,135.26
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,606,135.26	9,063,477.51

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ		Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	2022				
2	Өмчид гарсан өөрчлөлт		22,874,000.00	150,000,000.00	13,473,298.22	186,347,298.22
3	Залруулсан үлдэгдэл					
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-32,488,615.68	-32,488,615.68
9	оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	2023	22,874,000.00	150,000,000.00	-19,015,317.46	153,858,682.54
11	Залруулсан үлдэгдэл					
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-156,449.88	-156,449.88
17	оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	2024	22,874,000.00	150,000,000.00	-19,171,767.34	153,702,232.66


3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Завхан аймгийн “Баруун бүсийн тамирчдыг олимпд бэлтгэх төв” ОНӨТҮГ нь Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, аймгийн хэмжээнд усан спортыг хөгжүүлэх, сургалт, хүмүүжлийн үйлчилгээ, төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэх гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Байгууллагын 2024 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 69 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин



Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын зөвлөл нь 2024 оны ажлын төлөвлөгөөндөө 5 ажил хийхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт бүрд удирдамж батлуулж, хяналтаар илэрсэн зөрчлийг арилгаж ажилласан байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн “Баруун бүсийн тамирчдыг олимпд бэлтгэх төв” ОНӨТҮГ -ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Завхан аймгийн “Баруун бүсийн тамирчдыг олимпд бэлтгэх төв” ОНӨТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19,757.3 мянган төгрөгөөр буюу 10.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	5,329.1	5,846.1	558.6
Бараа материал	33,822.7	38,554.8	4,732.1
Үндсэн хөрөнгө	132,813.8	107,350.2	(25,463.6)
Нийт хөрөнгө	180,571.8	160,814.5	(19,757.3)
Өр төлбөр	26,713.1	7,112.3	(19,600.8)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	180,571.8	160,814.5	(19,757.3)

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайланд онд:

Бараа материал эхний үлдэгдэл 5,329.1 мянган төгрөг, өөрийн орлогоор худалдан авсан 49,586.00 мянган төгрөгөөр нэмэгдэж, 49,069.00 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 5,846.1 мянган төгрөг болсон байна.

Үндсэн хөрөнгийн хувьд 629.9 мянган төгрөгийн хөрөнгийг шийдвэрийн дагуу нэмэгдэж, жилийн эцэст 107,350.2 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 26,093.5 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг түрээсийн орлогын 19440.0 мянган төгрөг, 971,300.00 нийт зарлагыг мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Гүйцэтгэлээр 1,044,866.7 мянган төгрөгийг төвлөрүүлэн зарцуулж, төсвийн нийт зардлын гүйцэтгэл 100 хувьтай зарцуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 12,693.1 мянган төгрөг байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/мянган төгрөг/

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Байхгүй			
2	Байхгүй			
3	Байхгүй			
ДҮН			0	0

Тайлант оны худалдан авах ажиллагаатай холбоотой ажил үйлчилгээ явагдаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Завхан аймгийн “Баруун бүсийн тамирчдыг олимпд бэлтгэх төв” ОНӨТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Б.Мөнхнасан гүйцэтгэж, хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Х.Болдбаатар, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн “Баруун бүсийн тамирчдыг олимпд бэлтгэх төв” ОНӨТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дүгээр сарын 07-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1,044,866,672.0 төгрөгөөс 1.5 хувиар буюу 15,673.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 11,754.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 20 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завхан аймгийн “Баруун бүсийн тамирчдыг олимпд бэлтгэх төв” ОНӨТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж, албан шаардлага өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өглөг болон авлагын барагдуулалтыг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

Аудитаар алдаа зөрчил илрээгүй тул бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтрэх алдаагүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

5.2 Албан шаардлага

1 заалт бүхий 16,000.0 төгрөгийн дүнтэй албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал..

Илрүүлэлт:

Фитнесийн үйл ажиллагааг өмнө эрхэлж байсан иргэн н.Цогтбаярын түрээсийн төлбөр 3,496,0 мянган төгрөгийн үлдэгдэл байна.


Өгсөн зөвлөмж:

Фитнесийн үйл ажиллагааг эрхэлж байсан иргэн н.Цогтбаярын түрээсийн төлбөр 3,496,0 мянган төгрөгийн үлдэгдэлийг 2025 оны 06 дугаар сарын 01-ны дотор барагдуулах арга хэмжээ авах, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6. дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл



/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны Тоо	Тоо	Дүн
Албан шаардлага	1	16,000,0 00	0	0	1	16,000, 000	0	0	0	0	0	0
Зөвлөмж	1	3,496,07 0.95					1	3,496,070. 95				
Дүн					1	16,000, 000	1	3,496,070. 95				

АУДИТЫН ТАЙЛАНГ:


ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

Х.БОЛДБААТАР

Б.МӨНХНАСАН

Огноо: 2025-03-15

